



Хичээл №3

Төв Азийн улс орнуудын хувцасны загвар ба Торгоны зам

(Costumes of the Central Asia Mongolia, The silk Road)



Дараах чиглүүлэгч эхүүдийг уншиж, дэлгэрүүлээд

“Утгын сүлжээ” 2- той ажиллаарай.

1. Торгоны зам нь МЭӨ 2-р зуунаас 18-р зууны хооронд Зүүн ба Барууныг холбосон худалдаа арилжаа, эдгээр бүс нутгуудын эдийн засаг, соёл, улс төр, шашин хоорондын харилцааны гол төв байсан тул түүгээр дамжин хувцасны төрөл бүрийн материал, гоёл чимэглэлийн өргөн солилцоо явагдаж, улс үндэстний хувцасны загвар харилцан нөлөөлөцөж байсан нь монгол хувцасны түүхийг судлахад ойлгогддог. Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум дэлхийн соёлын солилцооны төв байсан тул дэлхий нийтийн загварын төв байж, хаад, хатдын ордон тансаг зэрэглэлийн торгон хувцасны загварын ордон болж байв. Монголчууд дайн дажин хийж Монголын эзэнт улсыг байгуулсан хэдий ч XIII, XIV зуунд хөгжлийнхөө оргилд хүрч, нийт 15 сая км квадратад газар нутагт 100 сая ард иргэдийг энх тайван оршин тогтноулж байлаа. Тэд Ази тивээс Европ хүрсэн Торгоны зам дагуух улс орныг эзэлснээр бараг 6437 км урттай Торгоны замыг тэр чигт нь мэдэлдээ оруулсан ба баян бүрдийг тойрч байрласан хот суурингууд Монголын эрхшээлд байлаа. Торгоны зам бүхэлдээ Монголын эзэнт гүрний мэдэлд байсан билээ. Монголчууд торгоны замаар зорчих худалдаачдад найрсаг хандаж түүнчлэн Хятадаас Ойрх Дорнодтой хийх худалдааг хаах бус, харин ч дэмжиж, хөгжүүлэхийг зорьдог байсан.

Энэ бүхий л цаг үед монгол хувцасны загвар, хийц олон улс даяар тархсан.

2. Монголчууд дэлхийд анхдагч өртөөний тогтолцоог бий болгосон, торгоны замыг мэдэлдээ авсан нь тухайн үедээ өнөөгийн интернетийн үүрэг гүйцэтгэж байв.
3. Хятанчуудын байгуулсан Их Ляо Улс (X-XII зуун) Хятадын торгоны үйлдвэрлэлийн хөгжилд чухал нөлөө үзүүлжээ.
4. Тайван улсын Тайпэ хотын “Үндэсний ордон музей”-д Монголын эзэнт гүрний үеийн монгол дээдсийн тансаг зэрэглэлийн хувцасны загварыг тогтмол үзүүлдэг.
5. Эзэнт гүрний үед олон янзын өвөрмөц онцлогтой дээл хэрэглэж байсан бодит баримт өнөөдөр дэлхийн олон газрын музей, хувь цуглуулагчдын цуглуулгад байдаг.
6. Персийн түүхч Рашид ад Дин Монголчуудын хувцсыг судалсан.
7. Дундад зууны сүүл үед өрнө дахины барилга архитектур болон бүхий л урлагт роман, готик стиль үүсч хөгжсөнтэй адил Монголын эзэнт гүрэн, Юань гүрний үед монголчууд хувцаснаас эхлээд орон гэрээ хүртэл үнэт торгоор бүрж шилдэг торгонд умбаж байв.

Утгын сүлжээ 2

“Торгоны зам ба Монголын эзэнт Их Гүрэн”



ДААЛГАВАР

1. Дээрх утгын сүлжээтэй ажиллаад цаашид дундад зууны үеийн монгол хувцасны тархалтыг судлах аргачлалын тухай богино эссэ бичиж ирүүлээрэй.

Түүнчлэн, энэхүү утгын сүлжээнээс салбарлуулан, торгоны замын дагуух улс орнуудын хувцасны тухай утгын сүлжээ зохиож болох юм. Жишээлбэл, Цагаадайн Улсын хувцас, Ил хаадын Улсын хувцас, Юань гүрний хувцас, Алтан ордны Улсын хувцас гэж тус бүрт нь утгын сүлжээ зохион түүнийхээ дагуу системтэй нарийвчилсан суалгаа хийж, эцэст нь тус бүрийн онцлогийг тодруулах утгын сүлжээ зохиох нь тухайн үеийн монголчуудын хувцасны тухай цэгцтэй ойлголттой болох хамгийн үр дүнтэй арга болох төдийгүй төв азийн өндөрлөгийн бусад улс орон, үндэстэн угсаатны хувцасны талаар өргөн мэдээлэл олж авах болно.